

БАТЛАВ.
ОНГИ-ТААЦ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
/Н.БОЛДБААТАР/



БАТЛАВ.
“БУД-УНДРАМ” ХХК-НЫ
ЗАХИРАЛ
Х/Л.БАТДУЛАМ/



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2019 оны 05 сарын 20 -ны өдөр

Дугаар 01

Өвөрхангай аймаг

Нэг.Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын гаргасан 2019 оны 5-р сарын 10 -ны өдрийн 80 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Буд-Ундрaм ХХК-ны тоот хүсэлт, Онги-Таац голын сав газрын захиргааны олгосон 2019 оны 5-р сарын 20-ны өдрийн ус ашиглах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Онги-Таац голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах нэгжийн газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Батжаргал овогтой Даваацэрэн Ус ашиглагчийг төлөөлж Өвөрхангай аймгийн Уянга сум Цэцэн 7-р баг, улсын бүртгэлийн дугаар: 1011003061, регистрийн дугаар: 3553779, “Буд-Ундрaм” ХХК-ны захирал Л.Батдулам нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2019 оныг дуустал хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: MV-016711A тусгай зөвшөөрлийн дугаартай Өлтийн дээд хэсэг модот мухар алтны шороон орд нь унд ахуйн болон технологийн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ: 82347,5 м³/жил

2.2.1. Унд-ахуйд 787,5 м³/хон

2.2.2. Үйлдвэрлэлд 81560 м³/хон

2.2.3. Үйлчилгээнд 920 м³/жил /биологийн нөхөн сэргээлт/ , 1440,0 м³/жил /зам талбайн тоосжилт дарахад/

2.3. Усны чанар, найрлага: Ундны усны эх үүсвэр болох худгаас /голоос/ улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэрийн байршил: Өөрийн талбайд гаргасан 2 гүний худаг. Mastra frog маркийн насостой. Худаг-1 байршил 102° 17' 24", 46° 35' 18" ундарга 10,1 л/сек

Худаг-2 байршил 102° 17' 32", 46° 35' 11,9" ундарга 8,5 л/сек

Барилга байгууламж: Баяжуулалтанд уурхайн талбайд үүссэн хуучин ашиглаж байсан эргэлтийн усан сангуудыг ашиглаж шаардлагатай цэвэр усны хэрэгцээг 2 худгаас хангана. Усан сангийн гүн дунджаар 5м, урт өргөний хэмжээ 100x150м байна.

Тоног төхөөрөмжийн нэр, марк: . 2 гүний худаг Mastra frog маркийн насостой, D-100 маркийн насосоор угаах төхөөрөмжрүү усаа шахна.

2.5. Хаягдал усны хэмжээ:

Стандартын шаардлага : Хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага MNS 4943:2016-г ханган ажиллана.

Хаях цэгийн байршил: Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг

Органик бодис, кг

Эрдэс бодис, кг

Хүнд металл, кг

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд ахуйн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулж, технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг тунаах усан санд хийж эргүүлэн ашиглахаар байна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуурын:Төрөл, нэр, дугаар: ДН-50 маркийн 2 ширхэг тоолууртай.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах **82347,5 м³** усны нөөцийн төлбөр **65'005'200** /жаран таван сая таван мянга хоёр зуу/ төгрөг.

2.10.1 Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээг ус ашиглалтын тайланд тусгана.

2.11. Ус ашигласаны төлбөрийг 6 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15 хүртэл 4 хувааж Өвөрхангай аймгийн төрийн сан банкны 100000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1 Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 6.2.3, 17.1.9, 7.5, 18.1.4, 19.1.2, 26.1, 30.1, 30.1.4, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2 Ус ашиглагч тал Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргүүдийг бүрэн хүлээнэ.

3.3 Талуудын эрх, үүрэг зөрчигдсөн тохиолдолд Усны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2019 онд биологийн нөхөн сэргээлтийг га-д, техникийн нөхөн сэргээлтийг ... га-д хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Ус ашиглагч тал тухайн оны ус ашиглалтын тайланг маягтын дагуу боловсруулж тус оны 12 сарын 01-ны дотор сав газрын захиргаанд хүргүүлнэ.
- 4.3. Ус ашиглуулагч тал гэрээний биелэлтийг жил бүрийн 12 сарын 25-ны дотор дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.3.2 Ус ашиглуулагч тал тухайн оны ус ашиглалтын тайланд тусгагдсан мэдээлэл бодит ажилтай уялдуулан дүгнэх ба гэрээг дүгнэсэн үнэлгээ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үнэлгээнд нөлөөлнө.
- 4.4. Ус ашиглагч тоолуур суурилуулах болон, уурхайн үйл ажиллагаа зогсохдоо тоолуурыг мэргэжлийн байгууллагын болон сав газрын захиргааны хяналтан дор авч, суурилуулах
- 4.5. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.6. Гэрээг доор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 4.6.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
- 4.6.2. Аль нэг тал татан буугдсан бол;
- 4.6.3. Усны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон
- 4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


Ус ашиглуулагчийг төлөөлж:

Онги-Таац голын сав газрын захиргааны
мэргэжилтэн

 / Б.Даваацэрэн/

Холбоо барих утас: 70322567,
88105551

Ус ашиглагчийг төлөөлж:

"Бул-Ундрал" ХХК-ий захирал
 / Л.Батдулам/

Холбоо барих утас: 99110409,
89081802